

**НЭГДСЭН ҮНДЭСТЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН
ШУГАМААР ХЭРЭГЖИЖ БУЙ “МОНГОЛД ҮЙЛДВЭРЛЭЛ ХӨГЖҮҮЛЬЕ”
ТӨСЛИЙН II ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
/2009 оны жилийн эцсийн байдлаар/

2010.02.10

<i>Д/д</i>	<i>Төслийн агуулга</i>		<i>Гүйцэтгэл</i>
1	Төслийн нэр, дугаар, код		"Монголд Үйлдвэрлэл Хөгжүүлсе-2" төсөл, МОН09/203 /00063219/
2	Төслийн хугацаа		2008 оны 10 дугаар сар – 2012 оны 3 дугаар сар
3	Төслийг баталсан баримт бичиг, шийдвэрийн төрөл, гэрээний дугаар, огноо		Төслийн гэрээний дугаар: 00050955, Огноо: 2008 оны 10 сарын 29
4	Санхүүжилтийн хэлбэр		Буцалтгүй тусламж
5	Санхүүжүүлэгч байгууллага		Нэгдсэн Үндэстэний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, Япон улсын Засгийн газар
6	Төслийн хэрэгжүүлэгч		Монгол улсын Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам, Жижиг, Дунд Үйлдвэрийн Газар
7	Төслийн чиглэл		Бичил бизнес эрхлэлт, жижиг ба дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих
8	Төслийн зорилго		Бичил, жижиг ба дунд үйлдвэрлэлийг дэмжсэнээр ядуурлыг бууруулах, ажлын байр шинээр бий болгох, орлого нэмэгдүүлэх
9	Төслийн хамрах хүрээ, салбар		Бичил санхүүгийн салбар, бизнесийг хөгжүүлэх үйлчилгээний салбар, маркетингийн салбар, хүнс, хөдөө аж ахуйн салбар, гар урлал, үйлдвэрлэлийн салбар, аялал жуулчлалын салбар
10	Төслийн зорилтууд		<ol style="list-style-type: none"> 1. Төслийн дэмжлэгийг хүртсэн бичил бизнес бүлийн үйлдвэрлэл тогтвортой хөгжиж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. 2. Бичил бизнес эрхлэгчдэд бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий орон нутгийн бизнес хөгжлийн “Үйлдвэрлэл хөгжүүлсе” төвүүд санхүү болон үйл ажиллагааны хувьд бие даасан төв болон хөгжиж, үйл ажиллагаа нь тогтворжин, үйлчлүүлэгчдийн хүрээ тэлсэн байна. 3. “Нэг суурин нэг бүтээгдэхүүн” санаачлага нь “Нэг сүүрин нэг бүтээгдэхүүн” Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагаанд бүрэн нэгдэж, төслийн үйл ажиллагаа төрийн үйлчилгээтэй уялдаж, хамтын ажиллагаа нэмэгдэнэ.
11	Зардал	Төслийн батлагдсан төсөв	Нийт 1, 207, 775 ам. доллар, үүнээс 2009 онд 52,986 ам доллар
		Төсвийн гүйцэтгэл	2009 онд 28,703 ам доллар
		гүйцэтгэлийн хувь	Нийт төсвийн 2.4%, 2009 оны гүйцэтгэл 50.2 %
12	Төслийн гүйцэтгэлийн хувь		Төслийн гүйцэтгэл 20%, 2009 оны гүйцэтгэл 50%
13	Төслийн явц, хүлээгдэж буй үр дүнд хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйл		Төслийн хүрээнд төлөвлөсөн ажлууд хийгдэж байна. 2009 онд төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнууд болон төслийн менежерийг сонгон авах ажлын явц 11 сар хүртэл үргэлжилснээс шалтгаалан төлөвлөгдсөн ажлын 65 хувь нь 2010 онд хийгдэхээр хойшлогджээ.
14	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)		Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор баталсан ”Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ,

үнэлгээ хийх журам"-ыг удирдлага болгож удирдлага болгож, төслөөс 2009 онд хийж гүйцэтгэсэн ажлын товч тайланг үндэслэн хийв. Төслийн ажлын төлөвлөгөө, үр дүнгийн талаарх судалгааг хүргэгдэж ирээгүй болно.

Төслийн 2009 оны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 9 үйл ажиллагаа, 21 арга хэмжээ тусгасан. Төслийн гүйцэтгэл 20, 2009 оны гүйцэтгэл 50 хувьтай дүгнэгдэж байна.

Төслийн дэмжлэг хүртэгчдийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж, тэдний нэн тэргүүний хэрэгцээг тодорхойлох ажлыг төлөвлөн төслийн эхний шатанд дэмжлэг авсан бизнес бүлүүдийг хамарсан судалгааны хийжээ. Хийгдсэн судалгаанд дүн шинжилгээ хийн, цаашид дэмжлэг үзүүлэх чиглэлээ боловсруулан батлуулах ажил дутуу байна.

Төслийн дэмжлэг хүртсэн бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүдийг МХАҮТ, УБ хотын захирагчийн алба хамтран зохион байгуулсан Улаанбаатар түншлэл-370 үзэсгэлэн худалдаа, ХХААХҮЯ-аас зохион байгуулсан Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаанд оролцуулан борлуулалт хийгдсэн байна. Булган аймагт тарьж ургуулдаг бог будаа өөрийн бүтээгдэхүүний худалдааны кодыг зөв хэрэглэсний учир шагнал хүртсэн. Өвөрхангай аймгийн сарлагийн хөөврөн бүтээгдэхүүн оёосгүй эдлэлийн шинэ технологи нэвтрүүлсэн учир мөн шагнал хүртсэн. Төлөвлөлтөд ямар үр дүнд хүрэхээр тусгагдсан нь тодорхойгүй, тайланд бизнес бүлүүдийн орлого, бүтээгдэхүүний борлуулалт өмнөх оныхоос хэдэн хувь нэмэгдсэн мэдээлэл тусгагдаагүй байна. Бүтээгдэхүүнүүдийг олон нийтэд сурталчилах, борлуулалтыг нэмэгдүүлэх үүднээс МҮХ-2 төслийн вэб танилцуулга, бүтээгдэхүүний цахим дэлгүүр хийх ажил явагдаж байна. Гэвч уг ажил удаашралтай байна.

Төслийн дэмжлэгийг хүртэж байгаа үйлдвэрлэгчдийн бичил санхүүгийн үйлчилгээ хүртэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор МҮХ-2 төслийн ЗБС-г ажиллуулах журмыг боловсруулахаар төлөвлөн, зээлийн баталгааны сан ажиллах бүтцийг өнөөгийн байдалтай нийцүүлэн хянах, харах, зарим түнш байгууллага, цаашид хамтрах боломж бүхий байгууллагын төлөөлөгчидтэй уулзах, НҮБХХ-ийн техникийн бүсийн зөвлөхтэй зөвлөлдөх ажлууд хийгдсэн.

Бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий "Үйлдвэрлэл хөгжүүлэ" төвүүдийн чадавхийг сайжруулах зорилгоор орон нутгийн бизнес бүлийн хөгжил санаачлагын зохицуулагч болон "Үйлдвэрлэл хөгжүүлэ" бүсийн төв ажиллуулах гэрээт 4 төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, захиргааны хүчин чадавхийг үнэлэх анхан шатны мэдээлэл цуглуулж, анхан шатны боловсруулалт дүн шинжилгээ хийсэн. Санхүүгийн болон захиргааны бичиг баримт хөтлөлтийг хянан шалгасан. Баримт бичиг хөтлөлтийг сайжруулах хэрэгцээг тодорхойлон төвийн зохицуулагчдад зөвлөгөө өгсөн. Бизнес бүлийн ахлагч нар, НСНБ бүлийн зохицуулагчидтай бүлгийн ярилцлага хийж, санхүүгийн бичиг баримт хөтлөлт, тайлан гаргах талаар сургалт явуулсан. "Үйлдвэрлэл хөгжүүлэ" төвүүдийн чадавхийг үнэлэх ажлыг үр дүнд хүргэн, цаашид дэмжлэг үзүүлэх чиглэлээ тодорхойлох нь зүйтэй.

"Нэг суурин нэг бүтээгдэхүүн" санаачлага "Нэг суурин нэг бүтээгдэхүүн" Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагаанд бүрэн нэгдэж, төслийн үйл ажиллагаа төрийн үйлчилгээтэй уялдаж, хамтын ажиллагаа нэмэгдэх зорилгоор ЖДҮГ-тай хамтран ажиллаж

		<p>байна. Цаашид Шадар сайдын дэргэдэх Бүсчилсэн хөгжлийн хорооны НСНБ хөтөлбөр болон ЖДҮГ-ын үйл ажиллагаанд төслийн оролцоог хангаж ажиллах юм байна.</p> <p>Төслийн удирдлага, зохион байгуулалтын хувьд төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнууд болон төслийн менежерийг сонгон авах ажил удаашралтай явагдан, 2009 оны 11 сард төслийг нэгж бүрджээ. Тайлант хугацаанд төслийн нэгж, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн мэргэжилтнүүдтэй хамтран төслийн 4 төвийн үйл ажиллагаанд ХШҮ хийн, орон нутгийн зохицуулагч нарын захиргааны болон түнш байгууллагуудын институцийн чадавхи зэргийг хянасан. Төслийн ХШҮ-ний ажилтан нь судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажлын аргачлалыг боловсруулж байна.</p> <p><u>Зөвлөмж:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө болон оны ажлын төлөвлөгөөнд хүрэх үр дүн, түүнийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгах, төслийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналтыг төрийн албан ёсны хэлээр үйлдэх, тайлан, төлөвлөгөөг хугацаанд нь тогтмол ирүүлэх, 2. Төлөвлөлтөнд тусгагдсан орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хэрэгцээг тооцох, “Үйлдвэрлэл хөгжүүлье” төвүүдийн чадавхийг үнэлэх талаар хийгдсэн судалгаанд дүн шинжилгээ хийн, цаашид дэмжлэг үзүүлэх чиглэлээ боловсруулан батлуулах, 3. Төслийн хэрэгжүүлэлтийг идэвхжүүлэх,
14	Төслийн удирдагч, хаяг, утасны дугаар	Ц.Батхүү, МҮХ-2 төслийн үндэсний менежер, утас 99180932

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА